



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.2.3, Засгийн газрын “Гадаадаас 2015 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” 2015 оны 2 дугаар тогтоолын 4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журманд нэмэлт өөрчлөлт оруулах, журмыг боловсронгуй болгох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Л.Зэндмаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О. Баяр/-т даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080795

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 10 өдрийн
231 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Л.Зэндмаа, Эрүүл мэнд, спортын яамны Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Ч.Зулцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа төлөвлөлт, статистик мэдээллийн албаны дарга
- Гишүүд:
- Х.Өлзий-Орших, Эрүүл мэнд, спортын яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн мэргэжилтэн
- Б. Пүрэвжав, Эрүүл мэнд, спортын яамны Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
- Ш.Мөнгөнцэцэг, Эрүүл мэнд, спортын яамны Хууль, эрх зүйн мэргэжилтэн
- Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал
- Г.Ганзаяа, Хууль зүйн яамны Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
- Б.Мөнхтуул, Сангийн яамны Зарлагын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
- Д.Ренчиндорж, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
- Ц.Амаржаргал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа төлөвлөлт, статистик мэдээллийн албаны мэргэжилтэн
- О.Энхцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа төлөвлөлт, статистик мэдээллийн албаны мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 10 өдрийн
231 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Үндэслэл:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 22 дугаар зүйлийн 22.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1, 24.3 дахь заалтуудын хэрэгжилтийг тус тус хангахад доорх бэрхшээлүүд байгаа тул журамд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага байна. Үүнд:

1. Гадаадаас Монгол улсад ажиллах хүч оруулж ирж буй компаниудтай холбоотой үүрэг, хариуцлагын талаар заалт журамд тусгагдаагүй;
2. Гадаадаас ажиллах хүч оруулж ирж буй зарим компани гадаад иргэдийг шинжилгээнд хамруулалгүй хувийн лабораториор шууд тамга даруулах, гарын үсэг зуруулах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага шаардлага тавихад түүнийг үл биелүүлэх;
3. Гадаад иргэдийг 6 сар тутам үзлэгт хамруулна гэсэн боловч одоогоор хамруулж байгаа эрүүл мэндийн байгууллага байхгүй зэрэг зөрчил дутагдал байна.

Зорилго:

Монгол улсад хөдөлмөр эрхлэх гадаад иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулах.

Үйл ажиллагааны чиглэл:

Журмыг шинэчлэн боловсруулахад Эрүүл мэнд, спортын яам, Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Сангийн яам дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

1. Хамтарсан тушаалыг шинэчлэн хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн үндэслэл зохицуулалтыг хэрхэн тусгаж өгөхийг судлах.
2. “Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэнд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2013 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 159/A/89 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж буй байгууллагуудаас тушаалыг хэрхэн сайжруулах талаар санал авах /ЭМСЯ, ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд, Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа, мэдээллийн үндэсний төв, Хууль зүйн яам, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар/.
3. Ирсэн саналыг тусган төслийг боловсруулж, холбогдох яамд, газруудад илгээн саналыг авч тусгах.
4. Хамтарсан тушаалын шинэчилсэн төслийг батлуулах.

Хугацаа: 2015 оны 05 сараас 2015 оны 3-р улирал.

Хүрэх үр дүн:

Монгол улсад хөдөлмөр эрхлэх гадаад иргэдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдалтын чанар, бүртгэл, мэдээлэл сайжирсан байна.